



НИЙСЛЭЛИЙН АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2014 оны 07 сарын 08 өдөр

Дугаар А/44

Улаанбаатар хот

“Дээлтэй монгол-2014” наадам зохион байгуулах тухай

Монгол Улсын Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.2, Үндэсний их баяр наадам зохион байгуулах хороо, нийслэлийн Засаг даргын Тамгын газар, нийслэлийн Аялал жуулчлалын газрын гурвалсан гэрээ, тус газрын Дүрмийн 2.3 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Монголчуудын уламжлалт соёлыг гадаад, дотоодод сурталчлан таниулах, түгээн дэлгэрүүлэх зорилготой “Дээлтэй Монгол-2014” наадмыг Их эзэн Чингис хааны нэрэмжит талбайд 2014 оны 7 дугаар сарын 13-ны өдөр зохион байгуулахыг эвент хариуцсан мэргэжилтэн /Б.Оюунзул/-д үүрэг болгосугай.

2. “Дээлтэй Монгол-2014” наадмыг зохион байгуулах ажилд шаардагдах зардлын төсвийг хавсралтаар баталсугай.


3. Наадам зохион байгуулахад шаардагдах төсөв 14,999,500 /Арван дөрвөн сая есөн зуун ерэн есөн мянга таван зуу/ төгрөгийг холбогдох зардлаас тооцож гаргахыг ахлах нягтлан бодогч /П.Ариунаа/-д зөвшөөрсүгэй.

ДАРГА

Э.БАТТУЛГА



Нийслэлийн Аялал жуулчлалын газрын
даргын 2014 оны ... сарын ... өдрийн
тоот гуцаалын хавсралт



"ДЭЭЛТЭЙ МОНГОЛ - 2014" НААДАМ ЗОХИОН
БАЙГУУЛАХ ЗАРДЛЫН ТӨСӨВ

№	Зардлын зүйл	Тоо хэмжээ	Нэгж зардал	Нийт зардал
1	Анонс хэвлүүлэх /6x18м2/	108	6,750	729,000
2	Самбарт байршуулах /600x1800/ 5 өдөр	5	100,000	500,000
3	Фото стикер хэвлүүлэх /1x1.5м2 x 8 ширхэг/	8	22,500	180,000
4	Фото стикер хэвлүүлэх /1.4x2.94м2 x 4 ширхэг/	4	37,500	150,000
5	Самбарт байрлуулах ажлын хөлс /12 ширхэг/	12	11,000	132,000
6	Урилга, хөтөлбөр/ англи, монгол хэлээр/	200	800	160,000
7	Эх бэлтгэл /урилга, хөтөлбөр, анонс, фотостикер/	5	25,000	125,000
8	Өргөмжлөл - 7 ширхэг	7	60,000	420,000
9	Баярын жагсаалд оролцогч байгууллага, хамт олонд олгох пайз самбар -35 ширхэг	35	10,500	367,500
10	Чингис хааны талбайд цахилгаан татах	1	150,000	150,000
11	Тайзны чимэглэл	1	500,000	500,000
12	Тайз, хөгжим <u>аппаратур</u> , лед	1	5,000,000	5,000,000
13	Телевизийн рекламн эх бэлтгэл	30сек	20,000	600,000
14	Шатахууны зардал	1	350,000	350,000
15	Шагналын сан /7 номинаци/-Шилдэг дүүрэг 1-р байр	1	1,300,000	1,300,000
	Шилдэг дүүрэг 2-р байр	1	1,100,000	1,100,000
	Шилдэг дүүрэг 3-р байр	1	1,000,000	1,000,000
	Шилдэг байгууллага	1	500,000	500,000
	Шилдэг эрэгтэй хүүхэд	1	100,000	100,000
	Шилдэг эмэгтэй хүүхэд	1	100,000	100,000
	Шилдэг монгол хос	1	300,000	300,000
	Шилдэг гадаад хос /гадаад оролцогч/	1	100,000	100,000
	Шилдэг бүжгийн хос	1	200,000	200,000
16	Шүүгчийн цалин	3	100,000	300,000
17	Принтерийн хор	2	15,000	30,000
18	Цэвэр ус	260	600	156,000
19	Найруулагчийн цалин	1	450,000	450,000
Нийт дүн				14,999,500₮

ТӨСӨВ ЗОХИОСОН:

НАЖГ-ЫН МЭРГЭЖИЛТЭН

Б.ОЮУНЗУЛ

ХЯНАСАН:

АХЛАХ НЯГТЛАН БОДОГЧ

П.АРИУНАА